



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№28 /242/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.02.10

Цаг үе, үйл явдал

## МОНГОЛ ЦЭРГҮҮД ДЭЛХИЙД ДАНСЛАГДСАНАА БАТАЛСААР ...



### АФГАНИСТАН УЛСАД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЭВ



Монгол Улсын Зэвсэгт хүчнээс "Исламын бүгд найрамдах Афганистан Улсад явагдсан "Тогтвортой эрх чөлөө", "Шийдвэртэй дэмжлэг" олон улсын ажиллагаанд АНУ-тай хамтран үүрэг гүйцэтгэсэн цэргийн багуудын туршлага, сургамж" сэдэвт хэлэлцүүлэг өчигдөр Зэвсэгт хүчний 350 дугаар ангид амжилттай зохион байгуулагдлаа. Тус уулзалт, хэлэлцүүлэгт нийт 22 ээлжийн цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүний төлөөлөл оролцож үүрэг гүйцэтгэж байх хугацааны талаарх туршлага сургамжаа

хэлэлцэв. Тус хэлэлцүүлэг цаашид Зэвсэгт хүчний 150, 120, 303, 032, 084, 027, 310, 311 дүгээр ангиуд болон Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн байрлалд ирэх 4 дүгээр сар хүртэл үргэлжлэх юм. Эдгээр хэлэлцүүлэг нь сонгон шалгаруулалт, ажиллагааны өмнөх бэлтгэлийн онцлог, үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүний судалгаа, ар тал, техникийн хангалтын байдал, сэтгэл зүйн бэлтгэлжилт, ажиллагаанд тулгарч байсан хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулсан туршлага зэрэг сэдвийн хүрээнд өрнөж байгаа юм.

Монгол цэргүүд хэдийн дэлхийд данстай болжээ хэмээхийн учир их. Тодруулбал, Монгол Улсын төрийн тэргүүнүүд олон улсад айлчлал хийх үед байнга яригдаж, магтаалын үг сонсдог сэдэв бол Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулагчид юм.

Үүний сүүлийн нэг жишээ нь өнгөрөгч долоо хоногт Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Бээжин хотноо зохион байгуулагдаж буй Өвлийн XXIV олимпын наадмын нээлтэд оролцохоор ирсэн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга А.Гутеррештэй уулзжээ. Эл уулзалтаар олон чухал асуудал ярилцсаны нэг нь Монгол Улсын Зэвсэгт хүчний НҮБ-ын энхийг сахиулах үйлсэд оруулж буй хувь нэмрийн тухай байв. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга А.Гутерреш Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэтэй Бээжин хотноо уулзаж байгаандаа баяртай байгаагаа илэрхийлээд Монгол Улс НҮБ-ын чухал түнш гэдгийг онцолж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын оруулж ирсэн хувь нэмэр болон далайд гарцгүй орнуудын эрх ашгийг хамгаалах чиглэлээр гаргаж буй хүчин

чармайлтыг өндрөөр үнэлдэгээ цохон тэмдэглэв.

Мөн АНУ-ын Ерөнхийлөгч Жо Байден Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд хандан хоёр улс дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг тохиолдуулан захидал илгээжээ. Уг захидалд хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны олон амжилтыг дурдсаны дотор цэргийн харилцааг чухалчлан өгүүлсэн байна. Үүнд, "Хоёр орны хоорондын тогтвортой бөгөөд үр өгөөжтэй цэргийн харилцаа нь бидний өргөн цар хүрээтэй түншлэлийн илрэл болж байдаг билээ. Африк, Ирак, Афганистан дахь олон улсын энхийг дэмжих болон эвслийн ажиллагаануудад хоёр арваны турш Монгол Улсын оруулсан хувь нэмэрт миний бие талархаж байна. Монгол Улсын Зэвсэгт хүчин нь мэргэжлийн түвшний энхийг сахиулагч, цэрэг дайчид гэсэн нэр хүндийг олон улсад нэгэнт олсон бөгөөд цаашид бид хамтарсан цэргийн сургуулалтаар дамжуулан хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх болно" хэмээн тэрээр захидалдаа бичжээ.

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ 30 КМ-ИЙН ЯВГАН МАРШ ҮЙЛДЭВ

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал 2021-2022 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу энэ сарын 9-ний өдөр 30 км-ын явган марш үйлдлээ.



### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,270,170 /69.8%/	2,171,173 /66.7%/	1,011,388 31,0%

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8073 +112	104	7852

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 403,700,512
Эдгэрсэн	Нийт: 323,730,844
Нас барсан	Нийт: 5,796,202

### Түүхэнд энэ өдөр

1932 он. Хувьсгалт Улаан цэргийн Зөвлөлийн 19 тоот тушаалаар Цэргийн эмнэлгийн хэлтсийг байгуулав.

1932 он. Хувьсгалт Цэргийн зөвлөлийн тушаалаар Цэргийн эмнэлгийн хэлтсийг МАХЦ-ийн хүн эмнэлгийн газар болгон өргөтгөсөн байна.

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-14	-35

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
34	24

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,855.00	2,857.0
EUR	3,255.0	3,263.0
CNY	448.50	449.30
RUB	38.50	39.00
JPY	24.70	24.85
KRW	2.40	2.43

### ЗУРХАЙ



2022.02.10 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 10/

ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХ МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:  
Өвчин өчүүхэн ирнэ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
08.07-18.06  
Барилдлага:  
Үл тохирох  
Шүтэн барилдлага:  
САНСАР  
Суудал: Мод

Энэ өдөр бар жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сэрэг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, гарагийг тахиж, тангараг тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, шиншүү хярвас гаргах, хүүхэд хөлд оруулахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойшоо мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



Монгол цэрэг энхийн үйлсэд

## ЭНХИЙГ САХИУЛАГЧ ЭМЭГТЭЙЧҮҮД ЧУУЛНА



Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг угтсан ажлын хүрээнд “Энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 3 дугаар сарын 4-ний өдөр Нийслэлийн Соёлын төв өргөөнд зохион байгуулахаар төлөвлөж байна.

Чуулга уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Монгол Улсын Засгийн газрын

гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд нар, НҮБ-ын суурин зохицуулагч болон Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн эмэгтэй цэргийн алба хаагчид оролцоно.

“Энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн чуулга уулзалт”-д зориулсан энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн

үүрэг гүйцэтгэлтийг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэнг Нийслэлийн Соёлын төв өргөөнд, эмэгтэй цэргийн алба хаагчдаас бүрдсэн ёслолын жагсаал, гардан тулаан, жагсаалын үзүүлэх тоглолт, хөгжимтэй жагсаалын үзүүлэх тоглолтуудаас бүрдсэн арга хэмжээг Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэлээ хангаж байна.

### ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

Цаг үе, үйл явдал

## “МОНГОЛ ЦЭРЭГ-ДЭЛХИЙН ЦЭРЭГ”

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойг тохиолдуулан “Монгол цэрэг-дэлхийн цэрэг” сэдвийн хүрээнд ангийн захирагчийн баталсан төлөвлөгөөний дагуу цөөнгүй ажлыг төлөвлөн зохион байгуулж байна. Тухайлбал, “Иракийн эрх чөлөө ажиллагаанд оролцсон бүрэлдэхүүнийг алдаршуулах” зорилгоор ангийн ахлагч, тэргүүн ахлагч Г.Гантулга нийт



бие бүрэлдэхүүнд дээрх ажиллагааны үүрэг зориулалт, цэргийн баг тус бүрийн үүрэг оролцоо, онцлогийн тухай танилцуулж богино хэмжээний түүхэн баримтат киног толилуулав. Мөн тус ангиас энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн нийт алба хаагчдыг алдаршуулж, монгол цэргийн дайчин уламжлал, алдар гавьяаг мөнхжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулан явуулж байна.

Ахлах дэслэгч  
Б.ДОЛГОРСҮРЭН

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ ЗАСВАРЛАЖ АШИГЛАЛТАД ОРУУЛАВ

Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Зэвсэгт хүчний засварын нэмэлт санхүүжилтийн хөрөнгөөр

Эрүүл мэндийн төвийн байр болон Цэргийн цагдаагийн тасгийн байрыг засварлаж ашиглалтад орууллаа.

Анги “Covid-19” цар тахлын нөхцөлд Эрүүл мэндийн төвийнхөө орон тоог нэмэгдүүлж, ангийн Эрүүл мэндийн төвийг II шатны эмнэлгийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл авах зорилгоор эмнэлгийн байрыг ангийн байрлалд өргөтгөн зохион байгуулж засвар, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Түүнчлэн Улиастай цэргийн хүрээний Цэргийн цагдаагийн тасгийн байрны дотоод засварын ажлыг өөрсдийн нөөц боломжоор засварлаж Энэ оны 1 дүгээр сарын 28-ны өдөр ашиглалтад оруулан, нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус Эрүүл мэндийн төвийн байр болон Цэргийн цагдаагийн тасгийн байрны дотор заслын ажил 100 хувь дууссан бөгөөд гадна заслын ажлыг энэ хавартаа хийж гүйцэтгэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Ахмад  
Н.МӨНХБААТАР



Дарга, ерөнхий редактор, хурандаа  
САНЖМЯТАВЫН  
ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний  
Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



“Соёмбо” сонин



“Дуулга” студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс: 10018

Цахим шуудан:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)